

МЭДЭЭЛЛИЙН ГРАФИК: ВИЗУАЛЬ СЭТГҮҮЛ ЗҮЙН АРГА ТЕХНОЛОГИЙГ
НЭВТРҮҮЛЭХ АСУУДАЛД

Г.Сумъяа*

* ХИС-ийн докторант

Түлхүүр үг: визуаль сэтгүүл зүй, электрон мэдээллийн хэрэгсэл, сэтгэл ханамжийн онол, мэдээллийн график, инфографик, 3D технологи, статистикийн мэдээ

Сэтгүүл зүй хөгжлийнхөө шинэ эрин үетэй золгоод багагүй хугацаа өнгөрлөө. Сонин сэтгүүл, электрон мэдээллийн хэрэгслүүд уншигч, үзэгч, сонсогчдын хүрээг тэлээд зогсохгүй, мэдээллийг олон түмэнд хүргэх технологидоо эрс шинэчлэл хийсээр байгаа билээ. Эдгээрийн нэг нь урьд нь Монголын ОНМХ-үүдэд зохих байр сууриа эзэлж, эдүгээ цагийн аясаар баяжин шинэчлэгдэж буй визуаль сэтгүүл зүй юм. Энэ тухай ярихын өмнө зарим зүйлийн талаар тогтож ярих нь зүйтэй.

ОНМХ-ийн ачаар уншигч, сонсогч, үзэгчид сонголтоо хийдэг бичигдээгүй хууль улам ч эрч далайцтай үйлчилдэг боллоо. Мэдээж “Ашиг, сэтгэл ханамжийн онол”-ын үзэл баримтлалаар хүмүүс тодорхой сонголт, боломжоо “ухааран” шийдвэрээ гаргахад ОНМХ-үүдийн “хувь нийлэмж адилсал”¹-ын нөлөө бодитой оршин тогтнож байна”. Мэргэжлийн бус ажил хэрэгч хүмүүсийн

гаргаж байгаа сонин, сэтгүүлүүд ч шуурхай шинж чанараараа мэдээллийн агентлагуудтай өрсөлдөх нь ерийн үзэгдэл болов. Түүгээр ч барахгүй хүмүүст сэтгэлийн таашаал олгох зорилго бүхий нийтлэл, нэвтрүүлэг, тэр тусмаа хөгжөөнт шоуг үзэхийн хажуугаар янз бүрийн мэдээлэл авч болохуйц сонирхолтой нэвтрүүлгүүд олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдийг багагүй сандарган, шинэ нөхцөлд шинэ арга барилаар ажиллахаас өөр аргагүйд хүргэв.

Ялангуяа Интернет ахар богино хугацаанд манай залуучууд, дунд насныхны мэдээллийн хамгийн дуртай, ирээдүйтэй хэрэгсэл нь болж чадсан байна. Сонин, сэтгүүл, ер нь хэвлэмэл мэдээллийн эрин дуусч байна гэж зарим судлаачид бичиж байсан нь үүнтэй холбоотой.

Дэлхийн сонины холбооны судалгаа ч үүнийг нотолж байна. Энэ байгууллагын тооцоолсноор, орчин үед нэг хүн сонин уншихад 34 орчим минут зарцуулж байгаа аж. Үүнийг улс бүрээр авч үзвэл хамгийн их уншигчтай орон гэгддэг Хятад 56, Норвег 49, Финлянд 48, Герман 39, Франц 31, АНУ, ОХУ-

дад 25 минутыг сонин уншихад зарцуулдаг ажээ.

ОХУ-ын хэвлэл, олон нийтийн харилцаа эрхэлсэн холбооны агентлагийн тооцоолсноор, Оросын иргэд өдөрт мэдээлэл авч байгаа нийт цагийн 46,6 хувийг телевиз үзэхэд, 41 хувийг радио сонсоход зориулдаг бол дөнгөж 4,7 хувийг сонин, хэвлэл уншихад зарцуулдаг аж. Энэ нь телевизийнхээс 10 дахин бага байгаа юм. Европ, Америкийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ч үүнийг тойрч өнгөрөөгүй. "Мэдээлэл, хэрэглэгч хоёрын тогтвортой харьцаа алдагдах вий"² гэж сэтгүүл зүй судлаачид болгоомжилдог болов.

Гэвч хэвлэл, мэдээллийн эрин дуусах учиргүй билээ. Сэтгүүл, ном, товхимол нь үнэт мэдээлэл агуулсан хэрэгсэл хэвээр байна. "Сэтгүүл, ялангуяа ном юмс, үзэгдлийн хөгжлийн тогтвортой үйл явцыг тусгадгаараа сонин шиг цаг хугацаагаар хязгаарлагддаггүй"³.

Орчин үед телевиз болон мэдээллийн бусад сүлжээгээр тарж буй мэдээ, мэдээллүүд юуны урьд хүлээн авахад хялбар, товч тодорхой, яруу тод байхыг хэрэглэгчид эрхэмлэдэг болжээ. Сонин, сэтгүүл, хэвлэмэл материалыг уншихад наад зах нь цаг их алддаг, бас үг, өгүүлбэрийн утгыг ухаж ойлгох гэж тархиа гашилгахаас эхлээд багагүй хүндрэл гардаг. Иймд унших дур сонирхлыг нь сэргээхэд орчин үеийн визуаль сэтгүүл зүйн арга технологи, хүчин зүйлүүд чухал үүрэгтэй гэж судлаачид үзэж байна. Визуаль арга эрт дээр үеэс улбаатай байна.

"Хэрэв түүх ойлгомжгүй эхэлж, тэр нь ойлгоход хүнд байгаа бол энэ мөчид графикийг ашиглах хэрэгтэй"⁴ гэж "USA Today" сонины анхны редактор Лори Демо зөвлөжээ. "Зуун удаа сонссоноос нэг удаа үзэх нь дээр" гэсэн цэцэн үг байдаг нь чухамдаа визуаль сэтгүүл

зүйн мөн чанарыг илэрхийлж байна. Энэ бол мэдээллийг уншаад биш, нүдээр харангуут мэдэрч, мэдэж, хүлээн авах боломжтой, бас онц сонирхолтой тийм арга технологиор дамжуулна гэсэн үг.

Ер нь мэдээллийг дамжуулах графийн аргыг эртний хүмүүс ахуй амьдралдаа хэрэглэж байсан баримт цөөнгүй бий. Ховдын Гурван цэнхэрийн агуйн хананд үлдсэн ан амьтны болон бусад зургууд, тухайн үед тэнд амьдарч байсан хүмүүсийн аж төрөл, гарал үүслийн тухай мэдээллийг агуулж байгаа нь мэдээж. Ийм жишээ манай улсын аль ч нутагт түгээмэл тохиолддог. Бас "чулуун ном" хэмээн нэрлэсэн хадны бичээсүүд ч ялгаагүй.

Египетийн ханын зургууд гурван мянган жилийн өмнөх түүхийг өгүүлдэг. Бичиг үсэггүй хүмүүс ч тэдгээр зургийг хараад хүн төрөлхтний өвөг дээдсийн шашин-гүн ухааны нарийн түвэгтэй үзэл баримтлал, түүхэн үйл явдлын мөн чанар, зан суртахуун, оюун санааны нь талаар барим тавим мэдээлэлтэй болдог. Дээрх зургууд хүн төрөлхтний хойч үед мэдээллийг дамжуулах нэг хэлбэр байсан гэж ойлгож болно. Эртний төвд хүмүүсийн үлдээсэн хадны зургаас төрөх, үхэхээс эхлээд дайн тулаан, бас бурханы сургаалийн талаар бүрэн мэдээлэл авч болдог.

1702 оны 3-р сарын 11-нд Английн "Daily Courant" сонинд Испанийн хаан Филиппын Кадис тэнгисийн тохойд хийсэн айлчлалын тухай материал нийтлэгдсэн өдрийг мэдээллийн график үүссэн өдөр гэж үздэг байна. Учир нь сэтгүүлч өөрийн бичвэрт Испанийн хааны морилон очих газар бүрийг нарийвчлан зурсан газар зүйн зургийг зурж оруулсан байж. Гэхдээ энэ зургийг газар зүйч биш, сэтгүүлч өөрөө

зурж оруулсан нь Испанийн хаан хэзээ, хаана, хэнтэй уулзах талаар уншигчдад түвэггүй мэдэх боломж олгосон аж.

XIX зууны эхээр "The Times" сонины эрүүгийн сэдэвт нийтлэлүүдэд мэдээллийн графикийг заавал оруулдаг уламжлалтай болжээ. Энэхүү график нь зөвхөн нэг сэтгүүлчийн төдийгүй, бас зураач, графикч, редактор, хянагч зэрэг олон хүний хүчээр бий болдог хамтын бүтээл юм.

Техникийн дэвшлийн үр дүнд мэдээллийн график эрчимтэй хөгжиж, агуулга, цар хүрээ нь өргөжин тэлж байна. 1898 онд "New York Journal" сонинд испаничуудын тавьсан минд өртсөн "Мэйн" хөлөг онгоцны сүйрлийн тухай материал нийтлэгджээ. Редакцийн газар энэ үйл явдлын тухай олон баримтад тулгуурлан бүрэн хэмжээний график зургийг бүтээн нийтэлснээр уг сүйрлийн талаар уншигчдад богино хугацаанд нүдээр үзсэнээс өөрцгүй барим тавим ойлголт олгосон байна.

Мэргэжлийн өндөр түвшинд бүтээсэн мэдээллийн график нь уншигчдад нөлөөлөх талаараа уг үйл явдлыг нүдээр үзсэн хүмүүсийн яриа, мэргэжилтнүүдийн үнэлэлт дүгнэлтээс илүү юм.

XX зууны эхээр визуаль сэтгүүл зүйн шаардлага, арга зарчимд нийцсэн шинэ маягийн хэвлэлүүд олноор гарчээ. Энэ бол мэдээллийг зөвхөн унших төдийгүй, бас график зургийг нь хараад шууд ойлгох өвөрмөц арга технологийн дагуу дамжуулж байгаа хэрэг юм. Энэ чиглэлд "The Illustrated London News, L'Illustration" зэрэг сэтгүүл ихээхэн ахиц дэвшилд хүрсэн байна.

Эдгээр сэтгүүл цөөхөн зураг чимэглэлтэй, бичвэр голлосон хуучин загварын сэтгүүлүүдийн дүр төрхийг үндсээр нь өөрчилж, мэдээ, мэдээллийг визуаль аргаар дамжуулах үзэл санааг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд анх

нэвтрүүлсэн гэж судлаачид үздэг. Орчин үед мэдээллийн график зохиогчид бодит байдлыг бодитойгоор тусгасан, бараг шугам зургийнх шиг нарийвчлалтай, ойлгоход хялбар, яруутод байхыг сэтгүүлийн ажилтнууд нэн эрхэмлэдэг болжээ. Сонин, сэтгүүлийн хуудаснаа ор нэрийн төдий схем зураг, таблиц биш, ойлгоход түвэгтэй статистикийн болон тоон мэдээллийг жирийн уншигчдад ойлгоход хялбар, сонирхолтой хэлбэрээр хүргэхэд дизайн зураг чимэглэлийн оновчтой шийдэл гаргахыг тэд зорьж байна.

Сэтгүүлчийн бичвэрийн зайлшгүй байх нэг гол элемент нь мэдээллийн график юм. Дэлхийн томоохон хэвлэлүүд комикс, диаграммаас эхлээд бие даасан бүрэн хэмжээний мэдээллийн графикуудыг визуаль сэтгүүл зүйн зарчимд тулгуурлан нийтэлж, олны хүртээл болгож байгаа нь үүний нэг нотолгоо юм.

"Сайн материал "Хэзээ?", "Хаана?", "Юу?", "Хэн?", "Яагаад?", "Яаж?" гэсэн асуултуудад бүрэн хариу өгдөг байх"⁵ гэсэн алтан дүрэм байдаг. Тодорхой орон зай, цаг хугацаанд болсон үйл явдлыг хөгжил хөдөлгөөнд нь шуурхай тусгаж, энгийн, ойлгомжтой, оновчтой үгээр товч тодорхой илэрхийлэх нь мэргэжлийн ур чадвартай холбоотой. Энэ нь уншигчдын оюуны эрэлт хэрэгцээ, нийгмийн захиалгад нийцэж, тэдний анхаарал, сонирхлыг гойд татдаг байх учиртай. Гэхдээ сэтгүүлчийн бичвэр шинжлэх ухааны чиглэлийнх үү, явцуу мэргэжлийнх үү гэдгийг боловсрол бага төдийгүй, мэргэжлийн хүмүүст ч ойлгоход бэрхшээл цөөнгүй. Иймд мэдээллийг нийгмийн аль ч хэсэг, бүлгийнхэнд ойлгогдохоор дамжуулах шаардлага гарна.

Мэдээллийг дамжуулах үндсэн хоёр арга байдаг. Энэ нь зураг чимэглэлийн

хэлбэрээр, бас аман юм уу, бичгийн хэлбэр юм. Хоёр дахь аргаар нь дамжуулах тохиолдолд бичвэрт орж буй үгс нь аль хэдийнэ танил болсон бол үгийн эхний гурав, дөрвөн үсэг нүдэнд өртмөгц, үлдсэн хэсэг нь ухамсарт автоматаар бууж, уг бичвэрийг чөлөөтэй, түргэн гүйлгэн уншдаг байна. Хэрэв үгс нь танил биш бол эсрэгээр эргэнэ.

Монголчууд юмыг ихэд бэлгэшээж, өөдрөг үзэл бодлоо ойлгомжтой дүрс, тэмдэг, зургаар илэрхийлж, хаданд үлдээсэн нь олонтаа тааралддаг. Ер нь бэлгэ тэмдгийн зүйлс бол өвөг дээдсийн маань ертөнцийг танин мэдэх нэг хэлбэр болж байжээ. Тийм зүйлсийг хармагц мөн чанар, агуулга санаа нь ухамсарт шууд буудагаараа онцлогтой. Тодруулж хэлбэл

үнэн бодитой мэдээллийг шууд хүлээн авч байгаа хэрэг юм.

Хэрэв уншигч зүүн гартаа ном бариад баруун гарынхаа эрхийг гозойлгож байвал "Энэ сайхан ном болжээ" гэж хэлээгүй ч гэсэн энэ санаагаа тодорхой илэрхийлж байгаа нь түвэггүй ойлгогдоно. Визуаль сэтгүүл зүйн иймэрхүү арга, элементүүд уншигчдын цагийг хэмнэх, богино хугацаанд үнэн бодитой, тодорхой мэдээллийг олж авахад тустай.

Замын хөдөлгөөнд оролцогчдод зориулсан гэрэл дохио, таних тэмдгүүдийг үгээр биш, зургаар илэрхийлсэн байдаг нь дээрхтэй холбоотой. Хэрэв бичгээр илэрхийлсэн бол жолооч

түүнийг унших гэж хурдаа саан бусдын хөдөлгөөнд саад учруулахаас гадна анхаарал сарнин, осол аваарьт ч орж болзошгүй. Хүүхэд гарцаар хөндлөн гарч байгаа тэмдэг байвал жолооч түүнийг хармагц ойр хавьд сургууль юм уу, ясли, цэцэрлэг байна гэдгийг түвэггүй ойлгож, дараачийн үйлдлээ хийнэ. Ер нь аливаа үйлдэл толгойд үг орохоос илүү хурдан байдаг.

Бэлгэ тэмдэг бол уран сайхны биш, сэтгэлгээний элемент учраас уг зүйлийн мөн чанарыг тодорхойлж буй хамгийн гол, нийтлэг шинж чанаруудыг сайтар ялгаж мэдэх шаардлагатай. Аливаа ард түмэнд ахуйн болон зан үйлийн давтагдашгүй онцлогууд байдаг. Хаалганыхаа дээд талд шижим хатгасан айл тааралдвал энэ айлд шинэ хүн

«

XX зууны эхээр визуаль сэтгүүл зүйн шаардлага, арга зарчимд нийцсэн шинэ маягийн хэвлэлүүд олноор гарчээ. Энэ бол мэдээллийг зөвхөн унших төдийгүй, бас график зургийг нь хараад шууд ойлгох өвөрмөц арга технологийн дагуу дамжуулж байгаа хэрэг юм.

Энэ чиглэлд "The Illustrated London News, L'Illustration" зэрэг сэтгүүл ихээхэн ахиц дэвшилд хүрсэн байна.

»

мэндэлжээ гэдгийг түвэггүй ойлгоно.

Нүүрэндээ хөө түрхсэн эртний киргизүүд уйлж орилолдож буйг кино дэлгэцээс харвал энэ овогт үхэл хагацал тохиолджээ гэдгийг мэдэх жишээтэй. Бас гахайн дүрс хятадуудад тарган цатгалан сайн сайхан аж төрөхийн бэлгэдэл бол мусульманчуудад доромжлолын утга агуулах г. м.

Ойлгоход түвэгтэй бичвэр, нэр томьёоны учир утгыг ойлгомжтой, энгийн, хялбар болгоход бэлгэ тэмдгийн зүйлс чухал үүрэгтэйг дээр дурдсан. Дэлхийн томоохон хэвлэлүүд энэ чиглэлд ажиллаж, ихээхэн үр дүнд хүрч байгаа билээ. "The New York Times" сонин дугаар алгасалгүй ний-

тэлж буй бичвэр, түүний утга агуулгыг нүдэнд бууж, сэтгэлд хоногштол илэрхийлсэн мэдээллийн график, зураг сэлтийг англи хэл мэддэггүй хүн ч олж хараад нийтлэлийн учир начрыг ойлгодог байна.

Мэдээллийн график буюу инфографик нь сэтгүүл зүйд гэхээсээ дизайнд илүү хамаатай юм. Яагаад гэвэл сэтгүүлчид өөрийн бичсэн нийтлэлийн агуулгыг олон түмэнд ойлгомжтой, хүртээмжтэй болгох шаардлагатай уялдуулан инфографик бүтээдэг болохоор сэтгүүл зүйд илүү хамаатай, илүү ойр гэдэг нь ойлгомжтой. Нөгөө талаар инфографик бүтээхийн тулд мэдээллийг олох, боловсруулах, олон түмэнд хүргэх үйл ажиллагаа сэтгүүл зүйн бичвэр бүрдүүлэх үйл ажиллагаатай адилхан, бас л сэтгүүл зүйн үүрэг, зарчмын дагуу хийгддэг билээ.

Түүнчлэн мэдээ, мэдээлэл цуглуулах, эх сурвалжтай ажиллах, бичих, боловсруулах ажлыг инфографикт орох нарийн ширийн зүйлс, зураг чимэглэл цуглуулах, зурах, боловсруулах үйл ажиллагаатай уялдуулан нэгэн зэрэг хийдэг байна.

Бичвэрийн агуулгыг илэрхийлэхдээ гэрэл зураг төдийхнийг оруулж, ор нэр болгодог хуучирсан арга барилаас татгалзах нь зураачийн үүрэг. Иймд тухайн объектын дүр зургийг тодорхойлохын тулд түүний хамгийн тод томруун, нийтлэг, онцлог шинж чанаруудыг билгийн нүдээр харж, бичвэрийн агуулгатай нягт уялдуулан давтагдашгүй, шинэлэг, сонирхолтой хэлбэрээр илэрхийлэх үүрэгтэй. Ийм нөхцөлд гэрэл зураг биш, сайтар бодож боловсруулсан инфографик буюу мэдээллийн график ашиглах нь туйлын зөв шийдэл болно.

Инфографик бүтээхдээ газар зүйн зураг юм уу, схем ашиглах тохиолдол

олонтаа гардаг. Зураг бол инфографын эртний жанр (төрөл зүйл) бөгөөд, түүнийг хэрэглэх явцад багагүй бэрхшээл тулгардаг. Тухайлбал "Хаана?" гэсэн асуултын хариуг бичвэрт зөвхөн нэрийг нь дурдаад өнгөрдөг бол зурагт түүнийг маш тодорхой тэмдэглэх шаардлагатай байдаг.

Тухайн үйл явдал болж өнгөрсөн нөхцөл байдлын тухай материал бэлтгэх явцад бодит байдлын ерөнхий дүр зургийг бүтээх хэрэгтэй болдог. Энэ нь уншигчдад бодит мэдээллийг үнэн бодитой хүргэх нэг шилдэг арга юм. Сэтгүүлч-графикчид энэ дүр зургийг бүтээхдээ 3D технологийг өргөн ашигладаг болсон байна. Үүнд асар их ажиллагаа ордог ч гэсэн үр дүн нь төдий чинээ их юм. Наад зах нь цаг хэмнэж, орон зайг хумихад тустай.

Сүүлийн үед манайд гарч байгаа зурагт сэтгүүлүүд, томоохон сонинууд визуаль сэтгүүл зүйн холбогдолтой материал үе үе нийтэлдэг ч гэсэн тэр нь тогтмол булантай адил хэвшил болоогүй байна. Харин шинээр нээгдсэн үзвэр үйлчилгээний газрууд, бас шинэ бараа таваараа борлуулах гэсэн супер маркетууд, ямар нэг ёслолын арга хэмжээ зохион байгуулах гэсэн бусад газрууд өөрсдийн зар сурталчилгааны хуудас, урилга заллага дээрээ визуаль сэтгүүл зүйн арга технологийг ашигласан график зураг зурсан нь цөөнгүй тааралддаг.

Авьяаслаг зураачид, бас энэ чиглэлээр мэргэшсэн гарын ур дүйтэй сэтгүүлчид, номын зураачид үйл явдлын ном зохиолыг хүртэл визуаль байдалд оруулан зурж байсан тохиолдол цөөнгүй билээ.

Статистикийн мэдээ бол инфографикийн сонгодог төрөл гэж болно. Ийм мэдээг инфографикийн аргаар ойлгомжтой дамжуулж болох агаад энэ нь

нэг талаар албаны элемент, нөгөө талаар визуаль сэтгүүл зүйн бие даасан материал болдог.

Инфографикийн шилдэг материал нь хүртээмжээрээ тухайн объектын талаарх сэтгүүл зүйн сонгодог бичвэрээс дутуугүй, магадгүй түүнээс давуу талтай. Объектын тухай түлхүүр мэдээллийг агуулсан хамгийн гол тайлбар зурагт тулгуурлан материалаа бэлтгэж болно. Чухам тэрхүү гол график зургаас диаграмм, зураг, схем, дүрслэл зэрэг үйл явдлын олон шугам салаалан гардаг.

Бичвэрийг визуаль байдалд оруулахдаа мэдээлэл, тоо баримт, цаг хугацаа, үйл явдал болсон газар, санал бодол, тайлбар зэрэг бүтцийн хэсгүүдийг нарийвчлан тодорхойлсон байхад илүүдэхгүй. Ингэснээр түүнийг визуаль байдалд оруулах уу, эсвэл бичгийн хэлбэрээр байлгах уу гэдгийг шийдвэрлэх боломжтой болно. Ямар ч нөхцөлд уран сайхны зураг чимэглэл, эсвэл янз бүрийн объектуудаас бүрдсэн диаграмм бүтээхийн аль аль нь ашигтай. Жишээлбэл, жүржийг хэрхэн хэрэглэж байгаа тухай статистикийн мэдээг мэдээллийн графикийн аргаар дамжуулахдаа жимсээр дүүрэн хайрцаг байхад л болно. Харин цаг хугацааг тодорхойлоход нэлээд түвэгтэй байдаг. Ийм нөхцөлд цаг хугацааг бэлгэ дэмбэрэлийн чанартай үгээр юм уу, эсвэл тоон утгаар нь илэрхийлж болно.

Дээр дурдсан сэтгүүл зүйн шинэ хандлагаас гадна улс төрийн, эрүүл мэндийн, ажил хэргийн, спортын, шинжлэх ухааны, урлаг соёлын, гэрэл зургийн, аналитик, баримтат шинэ сэтгүүл зүй гэхчилэн нийгмийн амьдралын салбар бүр сэтгүүл зүйн тусгах объект болж, цар хүрээгээ улам тэлж, нийгмийн захиалга, эрэлт хэрэгцээ нэмэгдсээр байна.

Сэтгүүл зүй бол аль ч утгаар аваад үзсэн байр суурь гэдэгтэй утга дүйдэг ажээ. Энэ бол нийгмийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагатай салшгүй холбоотой. Ийм учраас сэтгүүлч хүн зөвхөн ярих, үзүүлэх бага хэрэг. Хамгийн гол нь үйл явдлын мөн чанарыг мэдэрдэг, мэддэг, ургуулан боддог чадварыг өөртөө төлөвшүүлэх нь чухал.

“Надад хэлээд аль, би мартчихна, надад үзүүлээд аль, би санаж явъя, надад ухааруулаад аль, би ойлгоно” гэсэн үг байдаг нь чухамдаа сэтгүүлчийн бүтээлч үйл ажиллагааны мөн чанарыг илэрхийлж байгаа юм. “Бүтээлч сэтгэлгээний тулгуур зарчмуудыг бид санаж явах учиртай. “Би мэдэхийг хүснэ”, “Би чадна”, “Би эрсдлээс айхгүй”, “Би хуучнаасаа татгалзаж байна”, “Би шинэ зүйлийг хүлээн авч чадна” гэсэн итгэл, үнэмшил өөртөө төрүүлэх ёстой”⁶.

Мэдээллийн даяарчлалын эринд, хэвлэл мэдээлэл “дөрөв дэх засаглал” гэдгийг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч буй энэ үед аливаа асуудлыг олж харах төдийгүй, түүнийг шийдвэрлэх чадвартай, чөлөөтэй, нээлттэй, хариуцлагатай, оюунлиг, авьяаслаг сэтгүүлчдийг бэлтгэх нь Монголын сэтгүүл зүйд хийж буй шинэчлэлийн салшгүй хэсэг билээ.

Энэ бол мэдээллийг бүтээлчээр ашиглаж, насан турш боловсорч чаддаг, хийсэн үйдлийнхээ төлөө хариуцлага хүлээх чадвартай тийм л сэтгүүлчдийн тухай яриа юм. Орчин үед ажил олгогчид сэтгүүл зүй, сэтгүүлчийн мэргэжлийн тухай ярихдаа дээр дурдсан чанарууд үгүйлэгдэж буйг анзаардаг болсон байна.

Сэтгүүл зүй нийгэмд үйлчилж, нийгмийг сэрээж гэгээрүүлж, тэгснээр нийгмийн ухамсрыг төлөвшүүлэх үүрэгтэй нийгмийн өвөрмөц институт билээ. Энэ

зорилгодоо хүрэхэд зөвхөн мэдээллийн төрлөөр бичнэ, үйл явдлыг байгаа чигээр нь идэвхгүй мэдээлнэ гэдэг туйлын чамлалттай хэрэг. Иймд манай сэтгүүлчид зөвхөн мэдээлэх төдийгүй, асуудлын мөн чанар, учир шалтгааныг нээн илрүүлдэг, ургуулан боддог, мэдээллийг мэдлэг болгон хувиргадаг, асуудлыг бие даан шийдвэрлэдэг, өөртөө хариуцлага хүлээх чадвартай байх нь сэтгүүл зүйн шинэ хандлага, хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэж байгаа юм.

Юмс, үзэгдлийг тусгах хуучин загвараас татгалзаж, тусгах объектын цар хүрээ өргөжин, шинийг эрэлхийлж, мэдээллийг олон нийтэд амаар, бичгээр, бас визуаль байдлаар хүргэх нь түгээмэл болсон нь манай сэтгүүл зүйн шинэ хандлагын нэг илрэл юм.

Сэтгүүл зүй нийгмийн хөгжлийн түүхийг он жил, сар, өдөр, цагаар нь бичиж үлдээдэг, тодруулж хэлбэл нийгмийн хөгжлийн толь нь болдог учраас манай сэтгүүлчид ардчиллыг хөгжүүлэх, хамгаалахаас эхлээд сэтгүүл зүйд гарч байгаа шинэ хандлагыг соргоогоор мэдэрч, олон улсын мэдээллийн тасралтгүй урсгал эх оронд нь хэрхэн нөлөөлдгийг ухаардаг болсон нь тэдний нийтлэл, нэвтрүүлгүүдээс тодорхой харагдаж байна.

“Олон нийт бол мэдээллийн зах юм... Олон нийтийн харилцааны хүрээнд хүмүүсийн янз бүрийн эрэлт, амьдралын хэв маяг, зан үйл багтаж байдаг”⁷.

Энэ бүхэн сэтгүүл зүй, нийгэм хоёрыг холбох гүүр, уялдаа холбоог нь нягтруулах хэрэглүүр гэж ойлгож болно. Манай сэтгүүлчид өөрийн орны засаглалын тогтолцоо, Үндсэн хууль, хууль зүйн систем, улс төрийн үйл явц, эдийн засаг, нийгэм соёл, бусад оронтой энэ талаар тогтоосон харил-

цаа холбооны талаар нийтлэг тодорхой ойлголттой болж байна.

Шинжлэх ухааны салбарт ч ялгаагүй. Ер нь тодорхой салбарт дагнан мэргэшэх нь эх орныхоо сэтгүүл зүйг хариуцлагатай, ажил хэрэгч, сайн сэтгүүл зүй болгон өөрчлөн шинэчлэхэд тустай билээ.

“Авьяастай хүн бүх юманд авьяастай”⁸ байдагчилан сэтгүүлч дэлхийн сонгодог уран зохиолын талаар гойд боловсорсон байх учиртай. Шинэ сэтгүүл зүй үүнгүйгээр хол явахгүй. Сэтгүүлч хүн уран сайхны сэтгэлгээтэй, ургуулан бодох увдистай, бүр тодруулж хэлбэл мэдээллийг мэдлэг болгон хувиргах чадвартай, авьяастай байх шаардлагатай.

Сэтгүүл зүйг нийгмийн онцгой ач холбогдол бүхий мэргэжлийн хувьд нийгмийн хариуцлагын өндөр түвшинтэй холбож ярих нь зүйд нийцнэ. Нийгмийн эрс шинэчлэлийн үйл явцтай уялдан манай олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдэд гарч байгаа сөрөг үр дагавар (үнэн бодитой, тэнцвэртэй, олон ургальч, ил тод байх зарчмаас гаждаг, хэтэрхий нэг талыг барьдаг, улс төрийн тодорхой хүчин, олигархуудад үйлчилдэг, авлигад автдаг г. м.) бүхэн үүрэг, хариуцлага, мэргэжлийн нэр хүндээ дутуу ухаарсантай холбоотой.

“Дэлхийн олон оронд өргөн дэлгэрсэн ГОНЗО сэтгүүл зүй (толгой эргүүлэх, мунхруулах) Монголын сэтгүүл зүйд идэвхтэй нэвтрэх хандлагатай байгаа”⁹-г манай эрдэмтэн судлаачид тэмдэглэсэн нь бий.

“Банк, томоохон үйлдвэр, худалдааны нууцлаг амьдралыг “үгийн прожектороор гэрэлтүүлж” харах нь эрэн сурвалжлагч-сэтгүүлчийн гол зорилго төдийгүй, нийгмийн үүрэг нь байдаг”¹⁰. Үүнд үнэн бодит баримт

чухал ач холбогдолтой гэдэг нь мэдээж.

"Аливаа баримтын үндэс нь үйл явдал байдаг болохоор тэр нь утгыг агуулдаг"¹¹ гэж М.Горький хэлжээ. Өөрийн мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд эрэл хайгуул хийж, уншигч, үзэгч, сонсогчдын оюуны эрэлт хэрэгцээ, нийгмийн захиалгад нийцсэн, амьдралын олон тал, олон түмний эрх ашгийг хөндсөн арвин баялаг мэдээллийг (улс төр, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, боловсрол, экологи, нийгмийн г. м.) боловсруулж, нийтийн хүртээл болгох нь сэтгүүлчийн мэргэжлийн үүрэг юм. Энэ үүднээс авч үзвэл сэтгүүлчийн хөдөлмөр бол тасралтгүй үргэлжлэх бүтээлч үйл ажиллагаа болно.

Тэгээд ч ОНМХ-ээр дамжуулж буй бичвэрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг их, түүнийг бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа ч олон талтай.

Харилцаа холбооны технологи эрчимтэй хөгжиж, дэлхий нийтээр даяаршиж буй өнөө үед улс үндэстнийхээ зан үйл, түүх, соёлын уламжлалыг хүн төрөлхтний соёл иргэншлийн ололт, чиг хандлагатай хослуулах нь манай нэг эрхэм зорилго болж байна.

Сэтгүүлч үнэн бодитой мэдээллийг дамжуулж, танин мэдүүлэх, гэгээрүүлэх үүргээ биелүүлэхийн сацуу хүн төрөлхтний соёл иргэншлийн үндсэн үе шат, соёлын уламжлал, нийгмийн үнэт зүйлс, хэм хэмжээ, соёлын өв үеэс үед уламжлагдаж ирсэн механизм хэрхэн бүрэлдсэн талаар тодорхой төсөөлөл, мэдлэгтэй болох нь чухал байна.

Сэтгүүлч хүн хэдийгээр нийгмийн ажилтан гэгддэг (манай хэвлэл мэдээллийн тухай хуулиудад ингэж томъёолоогүй ч) боловч, эрхэлж буй ажил нь асар их авьяас, ур чадвар шаардсан

бүтээлч үйл ажиллагаа байдаг. "Энэ утгаараа сэтгүүлч бол нийгмийн харилцаанд хамгийн идэвхтэйгээр оролцогч юм"¹².

Манайд төдийгүй, дэлхийд нэрд гарсан гадаадын олон орны сонгодог зохиолчдын дийлэнх нь сонин, сэтгүүл, радио, телевизийн редакциас ажил амьдралын гараагаа эхэлж байжээ.

Хариуцлагатай сэтгүүл зүйг жинхэнэ утгаар нь төлөвшүүлэх нь хариуцлагатай, мэдрэмжтэй, мэдлэгтэй, ертөнцийг үзэх үзэл төлөвшсөн, улс төрийн ноён нуруутай, хүнлэг сэтгүүлчдээс ихээхэн шалтгаална. Иймд олон улсын экспертүүд, сэтгүүл зүй судлаачдын хүлээн зөвшөөрсөн сургалтын чиглэл бидэнд үндсэн чиг баримжаа болж болох юм.

Манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн аль нэг хүчин, эсвэл баян компанийн эзэд юм уу, олигархуудад худалдагдсан гэж шүүмжлэх хүмүүс ч байдаг. Ийм нөхцөлд тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлэг, нэр хүнд, эрэлт хэрэгцээний талаар нийгмийн нэг чухал хүчин зүйл болсон олон нийтийн санаа бодол ямар байгааг тандах зорилгоор социологийн судалгаа явуулдаг. Ер нь мэдээллийн зах зээлийн хатуу ширүүн өрсөлдөөний үед хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөрийн идэвхтэй дэмжигчидтэй байхыг эрхэмлэх нь зүйн хэрэг.

Харилцагчийнхаа сэтгэлийн дотоод ертөнцөд нэвтрэх чадварыг эзэмшсэн байх нь онцгой ач холбогдолтой. Сэтгүүлчид мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа янз бүрийн ажил мэргэжил, зан авиртай хүмүүс, нийгмийн тодорхой хэсэг, бүлгүүдтэй харьцдаг. Ийм учраас редакцийн газрууд өөрийн сэтгүүлч-уран бүтээлчдийг хүмүүстэй харьцах, шаардлагатай мэдээллүүдийг олох, боловсруулах, нийтлэлийнхээ

баатруудтай уулзах бололцоо нөхцөлөөр байнга хангадаг байх учиртай.

Ялангуяа нийтлэлийн баатруудынхаа сэтгэлийн дотоод ертөнцөд нэвтрэх, эв дүйг нь олж, итгэл хүлээсэн олон үзэл санааны эх сурвалжтай болох, эрсдлийг тооцох сэтгэл зүйн бэлтгэлтэй болгох зорилтыг мэргэжлийн байгууллагууд, ялангуяа сэтгүүл зүйн сургалт явуулдаг их, дээд сургуулиуд нэг эрхэм зорилгоо болгон хөтөлбөртөө тусгах ёстой.

Эрх зүйн боловсрол ажил мэргэжлийн нэг гол шалгуур болдог. Мэдээлэл олох, боловсруулахаас эхлээд мэдээллийн нууцыг хадгалахтай холбогдсон эрх зүйн орчныг мэдэхгүйгээр (манайд хязгаарлагдмал байдаг) сэтгүүлч мэргэжлийн өндөр түвшинд ажиллах боломжгүй.

Олон нийтийн анхаарал татсан үйл явдлын халуун мөрөөр сурвалжилж явахад нь тийм ч, ийм ч албан тушаалтан, дарга түшмэл хэнийг ч бүү оруул хэмээн тушаасан гээд сэтгүүлчдийг хөөж туудаг, түүгээр ч барахгүй камер хэрэгслийг нь хага цохидог тохиолдол цөөнгүй. Гэтэл сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд албан тушаалаа ашиглан саад учруулсан ямар ч албан тушаалтны иймэрхүү үйлдлийг гэмт хэрэг гэж үзэн 3-6 сар баривчлахаар Эрүүгийн хуульд заасан байдаг. Өөрийнх нь эрх ашгийг хамгаалсан хуулийн энэ заалтыг сэтгүүлч мэдэхгүйгээсээ болоод дээрх байдлаар хохирч, мэдээллийн тасралтгүй урсгалыг хангахаар нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хөсөрдүүлэх явдал хэвийн үзэгдэл болсон нь ажиглагддаг.

Орчин үед сэтгүүл зүйн ёс суртахуун-ёс зүйн түгээмэл хэм хэмжээ ихээхэн алдагдаж, энэ нь нийгэмд, ялангуяа залуу үеийнхэнд муугаар нөлөөлж байгаа талаар шүүмжлэн

ярилцаж байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Хүнд суртлын залхаан цээрлүүлэгч дэглэм нурж, хэвлэл мэдээлэлд тогтоосон хатуу хяналтыг халсны учрыг зарим сэтгүүлч дутуу ухаарч, ардчилал, ил тод байдлын далбаан дор нэг талыг барьж, хүнийг гүтгэх, нэр төрийг нь гутаах, сенсаац хөөцөлдөх, худал мэдээлэх, ашиг хонжоо хөөцөлдөх зэргийг туйлын эрх чөлөө мэтээр ойлгох явдал түгээмэл биш ч гэсэн байсаар байна. Түүний зэрэгцээ сэтгүүлчид мэргэжлийн хүнийхээ хувьд ч, иргэний хувьд ч улс орныхоо улс төрийн (системийн) онцлог, засаглалын тогтолцоо, улс төрийн нөхцөл байдал, хямрал, түүнээс гарах арга замын талаар тодорхой мэдлэгтэй, өөрийн бодолтой байх нь зүйн хэрэг.

"Улс төрийн мэдээллийг хэдий чинээ олон нийтийн нийгэм-сэтгэл зүйн асуудалтай холбон боловсруулна, төдий чинээ үр нөлөөтэй"¹³ тогтнох, цаашилбал нийгэмд, олон түмэнд хүлээн зөвшөөрөгдсөн, хэнээс ч, юунаас ч хараат бус бие даасан редакци байхын төлөө өрсөлдөж буй өнөөгийн нөхцөлд тэнд ажиллаж буй сэтгүүлчдийн эдийн засгийн боловсрол чухал үүрэгтэй гэдэг нь мэдээж.

Монголын сэтгүүл зүйн үйл ажиллагааны шинэ хандлагатай уялдан тухайн сэдвээр дэвшигдэн гарсан асуудлыг илэрхийлэх хэлбэр улам арвижин баяжиж байна. Энэ бол сэтгүүл зүйн бичлэгийн уламжлалт төрлүүдээс гадна төрөл зүйлүүдийг бүрдүүлэгч элементүүд шинээр орж ирсэн явдал юм. Тухайлбал нэг намын дэглэмийн үед рейтинг, хувилбарт бодол, туршилтын зарим элементүүд байсан болохоос биш эдгээр нь бичлэгийн бараг бие даасан төрөл зүйл болох хэмжээнд хөгжөөгүй

байсан билээ. Ер нь сэтгүүл зүйн үйл ажиллагааны чиг хандлагыг сэтгүүлчийн ур чадвар, бичлэгийн төрөл зүйлүүд, тэдгээрийг бүрдүүлэгч элементүүдээс салангид авч үзэх нь ихээхэн учир дутагдалтай.

Ишлэл

- ¹ Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ., 195 дахь тал.
- ² 2008. Современное журналистское образование (Фак. журналистики МГУ). М., с. 130.
- ³ 2002. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ., 8 дахь тал.
- ⁴ 1975. Журналистика в политической структуре общества (Под ред. Я.Н.Засурского). М., с. 70.
- ⁵ 2008. Современное журналистское образование (Фак. журналистики МГУ). М., с. 133.
- ⁶ Дэмбэрэл С. 2002. Монголын боловсрол ба оюуны хөгжил. УБ., 150 дахь тал.
- ⁷ Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ., 111 дэх тал.
- ⁸ Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ., 37 дахь тал.
- ⁹ Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ., 212 дахь тал.
- ¹⁰ Стеженский В. 1965. Нежелательные репортажи. М., с. 181.
- ¹¹ 1982. В помощь начинающим журналистам. М., с. 208.
- ¹² Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ., 364 дэх тал.
- ¹³ Болд-Эрдэнэ Б. 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ., 142 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2009. 1990 оны ардчилсан хувьсгал ба Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 1999. Нийгэм, улс төр, хэвлэл мэдээлэл. УБ.
3. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
4. Дэмбэрэл С. 2002. Монголын боловсрол ба оюуны хөгжил. УБ.
5. Зулькафиль М. 2010. Монголын олон нийтийн мэдээлэл: нэг үзэл суртлаас олон ургальч үзэл хүртэл. УБ.
6. Зулькафиль М. 2006. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн онол, практик. УБ.
7. 2002. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ.
8. Чойсамба Ч. 2006. Сонирхолтой сэтгүүл зүй. УБ.
9. 1982. В помощь начинающим журналистам. М.
10. 1975. Журналистика в политической структуре общества (Под ред. Я.Н.Засурского). М.
11. Стеженский В. 1965. Нежелательные репортажи. М.
12. 2008. Современное журналистское образование (Фак. журналистики МГУ). М.

Резюме

Статья посвящена новому направлению в монгольской журналистике – визуальной журналистике. Автор на основе примеров из практики СМИ раскрывает сущность, особенности и практическое значение визуальной журналистики. По мнению автора, суть визуальной журналистики состоит в подаче информации и материалов в максимально доступной и понятной для аудитории форме.